

# Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар

2022 оны II улирал хэрэгжилт /Сайхан-Овоо сум/

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Биелэлт (Хариуцах эзэн)	Хэрэгжилт	Хувь
МУ-ын хууль						
1	1	Ашигт малтмалын тухай /Шинэчилсэн найруулга/ 2006-07-08 Дугаар 2006.08.26	43.3.. Энэ хуулийн 43.2-т заасан төлбөрийг тухайн сум, дүүргийн төсөвт төвлөрүүлж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр шинээр бий болгох, боловсролын болон эрүүл мэндийн салбарт зарцуулах бөгөөд энэ талаархи журмыг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална. (43.1.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тэдгээрийн туслан гүйцэтгэгч нь Монгол Улсын иргэдийг ажлын байраар хангах үүрэг хүлээх бөгөөд тухайн хуулийн этгээдэд ажиллагсдын 10-аас дээшгүй хувь нь гадаадын иргэн байж болно. 43.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гадаадын иргэдийг энэ хуулийн 43.1-д зааснаас илүү хэмжээгээр авч ажиллуулсан тохиолдолд ажлын байр тутамд	Сумдын Засаг дарга	Тус суманд “Алтан тахь” ХХК нь Бор овоо нэртэй ашиглалтын лиценз эзэмшдэг боловч ашиглалтын үйл ажиллагаа огт явуулдаггүй тул тус заалт нь суманд хэрэгжээгүй.	0%

			хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр төлнө.)				
2	2	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01	18.1.1. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар хөтөлбөр баталж, хэрэгжилтэд хяналт тавих; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	НБХ ГБХЗХГ Сумдын Засаг дарга	Сумын ИТХ-ын дэргэд байгуулагдсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн ажлын төлөвлөгөөнд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх заалтууд оруулсан. Мөн сумын Хамтарсан багийн гишүүдийг шинэчлэн баталж, гишүүн бүртэй нууцийн гэрээ байгуулан ажиллаж байна.	100%	
	3		18.1.2. Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	НБХ ГБХЗХГ Сумдын Засаг дарга	Үйл ажиллагааны зардал тусгагдаагүй.	0%	
	4						
	5		19.1.1. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн	НБХ ГБХЗХГ	Сумын Эрх зүйн хөтөч багтай хамтран иргэдэд эрх зүйн боловсрол олгох	100%	

		хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Сумдын Засаг дарга	ажлын төлөвлөгөөнд ГБХТ тухай хуулийг сурталчлан таниулах арга хэмжээг төлөвлөж, иргэдэд гэр бүлийн хүчирхийллийн талаар эрх зүйн зөвлөгөө, мэдээллийг тогтмол хүргэж байна.	
	6	19.1.2. Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	НБХ ГБХЗХГ Сумдын Засаг дарга	Сумын Хамтарсан багийн гишүүдийг шинэчлэн баталж, гишүүн бүртэй нууцийн гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн Хамтарсан багийн 2022 онд ажиллах ажлын төлөвлөгөөг сумын ИТХ-ын шийдвэрээр батлуулан гаргаж ажиллаж байна.	100%
	7	19.1.3. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	НБХ ГБХЗХГ Сумдын Засаг дарга	Нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах ажил хийгдээгүй.	0%

3	8	Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01	55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	ТЗУХ Сумд Засаг дарга	<p>Сургалт: Төрийн албан хаагчын сургалтын төлөвлөгөөг 2 зорилтын хүрээнд 12 ажил төлөвлөсөн. Эхний хагас жилийн байдлаар хэрэгжилт 85% хэрэгжиж байна. Нийт ТАХ-д дотоодын 3 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар 6 сэдвээр зохион байгуулж нийт 72 албан хаагч хамрагдсан байна. ТА3-с зохион байгуулж байгаа 7 хоног бүрийн 4 дахь өдөр явагддаг сургалтанд давхардсан тоогоор 26 албан хаагч 20 удаагийн сургалтанд хамрагдсан.</p> <p>Нийгмийн баталгаа: Төрийн албан хаагчын сургалтын төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 10 ажил төлөвлөсөн. Эхний хагас жилийн байдлаар хэрэгжилт 70% хэрэгжиж байна. ЕБСургууль, хүүхдийн цэцэрлэгийн 2 багшийг сувилалд амруулахаар мэдээ судалгааг БШУ-ны газарт хүргүүлсэн. Хөрөнгө зарцуулаагүй.</p> <p>Төрийн албан хаагчдын амьдрах нөхцлийг нь сайжруулхаар ЗДТГ-аас ТАХ-с орон сууцны захиалга авч 12 айлын орон сууц бариулхаар барилгын компантай гэрээ хийж захиалга авч байна.</p>	70%
---	---	---	--	--------------------------	---	-----

4	9	Татварын ерөнхий хууль 2019-03-22 Дугаар 2020.01.01	8.1.. Татварын хувь, хэмжээг Улсын Их Хурал, түүний эрх олгосноор Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хууль тогтоомжийн дагуу тус тус тогтооно.	СТСХ ТХ Сумдын Засаг дарга	2020 оны 12 дугаар 18-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор 2021 онд төвлөрүүлэх Малын тоо толгойн албан татварын хэмжээг малын тэмээ 2000 төгрөг, Адуу 2000 төгрөг, Үхэр 2000 төгрөг, Хонь 400 төгрөг, ямаа 500 төгрөгөөр ноогдуулахаар тогтоосныг байгаль, цаг агаарын гамшигт үзэгдэл удаа дараа тохиолдож, өвөлжилт, хаваржилт хүндэрч их хэмжээний санхүүгийн хохирол гарсантай холбогдуулан Малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг 50%-иар бууруулсан ИТХ-ын 25 дугаар тогтоолыг 2021 оны 12 дугаар 18 –ны өдөр тогтоосон.  Тус олон нийтийн эрх ашгийг хөндсөн захиргааны хэм хэмжээний актыг Улсын нэгдсэн сангийн 5040 дугаарт бүртгүүлсэн.  Тогтоосон хувь хэмжээгээр малын тоо толгойн албан татварыг авч, орон нутгийн төсөвт төвлөрүүлж байна.	100%
УИХ-ын тогтоол						
5	10	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга	1.1.ж/. цар тахлын үед хүүхэд, зорилтот бүлгийн иргэдийн эрхийг хамгаалах, хүүхэд хамгааллын байцаагчийн тоог нэмэгдүүлэх, хүүхэд хамгааллын асуудалд нэн шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар	НБХ ГБХЗХГ Сумдын засаг дарга	Сумын Онцгой байдлын комисс, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын байгууллагатай хамтран ЗДТГ-аас гаргасан Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой пост, эргүүл, ерөнхий штабын жижүүрийн хуваарьт оролцож ЕБС дээр багш, ажилчдын	100%

		хэмжээний тухай 2021-07-07 Дугаар 2021 №67	харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг ямар ч нөхцөлд хасахгүйгээр, цогц байдлаар төсөвлөх, шаардлагатай тохиолдолд төсвийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх; (1/Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр:)		тусгай багийг хуваарийн дагуу ажиллуулсан. Түүнчлэн шаардлагатай санхүүжилтыг сумын Онцгой комиссын шийдвэрээр шийдвэрлэсэн.	
УИХ-ын байнгын хорооны тогтоол						
6	11	“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ	3.8.. Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулахад анхаарах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар	НБХ ГБХЗХГ Сумдын засаг дарга нар	Дундговь аймагт явагдсан гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалтад хамрагдсан. Цахим сургалтад 2 удаа хамтрагдсан. Хамтарсан баг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.	100%

			зөвлөл хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах.			
Ерөнхийлөгчийн зарлиг						
7	12	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46	3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	Бүх хэлтэс агентлаг, сумдын ЗД	2021 онд сумын Хэлний бодлогын салбар зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, 2022 онд шинэчлэн, төлөвлөгөө гарган ажиллаж байна. Үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор төсвийн 5 байгууллага, аж ахуй нэгжүүдийн гаднах хаяг, дотор албадын хаалганы хаягийг монгол бичгээр байршуулж хадах чиглэлийг өгч, уг ажиллагааг дүгнэж ажилласан.	100%
	13		4.. Энэхүү зарлигт дурдсан ажлуудад болон монгол хэл, бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх,	Бүх хэлтэс агентлаг, сумдын ЗД	Монгол хэл, бичиг үсгээ эзэмших, хэрэглэх, өвлөх, өвлүүлэх, хамгаалах, хөгжүүлэх зорилгоор Сумын Үндэсний бичиг үсгийн баярыг жил бүр тэмдэглэн	100%

			хамгаалах, хөгжүүлэх талаар идэвх санаачилга гарган ажиллахыг иргэд, олон нийт, эрдэмтэн судлаачид, шинжлэх ухааны ба хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллагуудад уриалсугай.		өнгөрүүлэх зорилго тавин ажиллаж байна. Тус Үндэсний баярыг 2022 оны 04 сард ЕБС-ын сурагчид, Төрийн албн хаагч, иргэдийн дунд тэмдэглэн өнгөрүүлсэн.	
8	14	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43	1.4. Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс зохион байгуулж буй албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалтад өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхийг бүрмөсөн хориглох;	ХЭЗХ Бүх агентлаг, Сумдын Засаг дарга	Төрийн байгууллагаас 2022 онд олон нийтийг хамарсан арга хэмжээ болох Малчдын Зөвлөгөөнийг 5-р сард зохион байгуулсан. Энэ арга хэмжээний үеэр согтууруулах ундаа болон сул агууламжтай ундааг иргэд хэрэглээгүй. ЗДТГ-аас хүлээн авалтын арга хэмжээг зохион байгуулаагүй болно.	100%
	15		2. Нийт иргэн, аж ахуй нэгж, байгууллага архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад санаачилгатай оролцох, баяр ёслол, тэмдэглэлт өдөр, ажлын байранд өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байхыг уриалсугай.	ХЭЗХ Бүх агентлаг, Сумдын Засаг дарга	2021 онд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг гаралт- 2 байсан бол 2022 оны 6-р сарын байдлаар гэмт хэргийн дуудлага мэдээлэл 0 бүртгэгдэн шалгагдсан. Өмнөх онын мөн үеийнхээс 100 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Архи согтууруулах ундаагаар худалдан борлуулдаг 6 аж ахуйн нэгжүүдэд хамтарсан 180 удаагийн шалгалт явуулж ажилласан. Мөн энэ ажлын хүрээнд эрх зүйн хөтөч багаас “Архи, тамхи түүний хор уршиг” сэдэвт сургалтыг 7-9-р ангийн 54 сурагчдад зохион байгуулсан.	100%
ЗГ-ын тогтоол						



9	16	<p>ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ / Угийн бичиг хөтлөх журам/ 2007-10-03 Дугаар 2007_257</p>	<p>2. Угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загварыг 2008 онд багтаан боловсруулж хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшинд даалгасугай. Хавсралт: 1.4. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга харьяа нутаг дэвсгэрийн нийт өрхийн хэмжээнд өрх бүрийг угийн бичиг хөтлүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах үүрэг хүлээнэ.</p>	<p>СУГ Сумдын Засаг дарга</p>	<p>Сумын хэмжээнд өрх бүрийг угийн бичиг хөтлүүлэх ажлын хүрээнд Сочлын төвийн өвийн ажилтан Д.Мягмаржав 05 сарын 11-ны өдөр иргэдэд Угийн бичиг хөтлөх ач холбогдлын талаар сургалтыг зохион байгуулсан.</p>	<p>30%</p>
10	17	<p>Төрийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2019-04-17 Дугаар 2019_149</p>	<p>3.. Иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхэд төрийн мэдээллийн сангаас гарах боломжтой лавлагаа, мэдээллийг шаардахгүй байх зарчмыг баримтлан технологийн дэвшлийг ашиглаж төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд хандан авах замаар шийдвэрлэх, “Үйлчилгээний нэгдсэн төв”-д ажиллах байгууллагын албан хаагчдын орон тооны дээд хязгаарыг батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг холбогдох сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, Шүүхийн ерөнхий зөвлөл (Н.Лүндэндорж)-д</p>	<p>ТЗУХ, ХЭЗХ УБХ, Сумдын Засаг дарга нар</p>	<p>Иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг цахимаар хурдан шуурхай, чирэгдэлгүй авахад 38 иргэнд Хур системээс мэдээлэл лавлагаа гарган өгч, 25 иргэний гар утсанд e-mongolia апплейкшнийг суулган өгч, цахимаар үйлчилгээ авах ач холбогдлыг таниулж байна. Цахимаар төрийн үйлчилгээг авах, тус үйлчилгээг үзүүлэх ажлыг Архив, бичиг хэргийн ажилтан давхар хийж гүйцэтгэж байна.</p>	<p>100%</p>

			зөвлөсүгэй.			
11	18	Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2020-01-15 Дугаар 2020_18	4.. Сумдад малын гаралтай түүхий эдийг бэлтгэх, хүлээн авах, стандартын дагуу ангилан ялгалт болон чанарын хамгаалалт хийж, зориулалтын дагуу хадгалах, тээвэрлэх, борлуулах сүлжээг хоршоодод тулгуурлан бий болгох талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	ХБТХОХ ХХААГ Сумдын Засаг дарга	Сайхан-Овоо сумын стандартын шаардлага хангасан мах, түүхий эд бэлтгэх, хадгалах зориултын агуулах байхгүй.  Малын гаралтай түүхий эдийг бэлтгэх, зориулалтын дагуу хадгалах тээвэрлэх зорилго бүхий Их бадрах хайрхан хоршоо нь хөргүүртэй мал нядалгааны цехийг барих төсөл бичиж сумын Хоршоо хөгжүүлэх санаас зээл хүссэн. Уг хүсэлтийг шийдвэрлэхээр холбогдох дүрэм журмыг судлах арга хэмжээг авахаар судалгааны шатанд явагдаж байна.	30%
<b>Нийт дүн:</b>			<b>3-0%, 2-30%, 1-70%, 11-100% хэрэгжилттэй байна.</b>			<b>72.3%</b>

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС